

Living the

LOTUS

Buddhism in Everyday Life

9
2017

VOL. 144

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН СУРГААЛ

Бусдын баяр хөөрийг хуваалцаж чаддаг хүн

Нэг хүн “эхнэрийнхээ дэргэд өөр эмэгтэйг магтахгүй байхыг хичээж байгаа” гэсэн юм. Яагаад гэвэл ээжийнхээ хийсэн хоолыг амттай гээд магтахаар эхнэр нь өөрийг нь амтгүй хоол хийдэг гэж гоочилж байна гэж хүлээж аваад гомдчихдог юм гэнэ.

Хүний баяр хөөр, зовлон гунигийг өөрийн мэт хуваалцаж чадна гэдэг ховор чанар. Тэр дундаа зовлон шаналалыг хуваалцаж чаддаг байлаа гэхэд магтуулах, албан тушаал дэвших үед нь чин сэтгэлээсээ баярлаж чаддаг байх амаргүй. Өнгөн дээрээ “баяр хүргэе” гэж хэлж байгаа ч дотроо “энэ хүн чадаж байгаа бол би

бүр ч илүү чадна” гэсэн бодол өөрийн эрхгүй төрдөг.

Хүн гэдэг өөрийн мэдэлгүй бусдын алдааг хайдаг томруулдаг шилтэй явдаг гэдэг. Өөрөөс нь хамаагүй чадвартай мундаг хүнийг “надтай л адилхан юм байна” гэж харан, өөртэйгөө адил түвшний хүнийг өөрөөсөө доор гэж дүгнэж орхидог.

Тиймээс бусдын баяр хөөрийг хуваалцаж чадаж байна уу үгүй юү гэдгээр нь тухайн хүний хувиа хичээсэн, аминч үзлээ хэр давж чадсаныг дүгнэх боломжтой.

Үүсгэн байгуулагчийн сургаал 9, 18-19х

Living the Lotus Vol. 144 (2017.09)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Мизүтани Шёокоо

Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Б.Мөнхцэцэг

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаагай гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СУРГААЛ

Сургаал “дамжуулах” ГЭДЭГ НЬ

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Сургаал дамжуулахын утга учир


Амьдралд олон янзын зүйл тохиолддог боловч бид зовж шаналж, гунигласан ч гэсэн тулгараад байгаа зовлон бэрхшээлийг хүлээн авч, даван туулах “билиг оюун”-ыг өөрийн болгохын тулд Бурханы сургаалыг сурч, амьдралдаа хэрэгжүүлдэг билээ.

Цаашлаад улам сайхан амьдрах “билиг оюун” ба “нигүүлсэхүйн сэтгэл”-ийг өөрийн болгохын тулд сурсан зүйлээ бусдад дамжуулах нь маш чухал үйл юм. Амьдралынхаа туршид 100 гаруй ном бүтээл туурвиж, бурханы сургаалыг энгийн хүмүүст ойлгомжтойгоор дамжуулсан буддын шашны Ринзай урсгалын Мацүбара багштан бол жинхэнэ сургаал түгээгч байсан. Тэрээр сургаал дамжуулах утга учрын талаар “сургаалыг бусдын төлөө биш, өөрийнхөө төлөө айлддаг” гэж хэлсэн байдаг. Мацүбара гуайн чин сэтгэлээсээ хүндэтгэдэг багш нь “Бид бясалгал үйлдэн, бурханд залбирч байгаа нь бусдын төлөө биш бүгд өөрийнхөө төлөө юм. Чи арай өөрийнхөө төлөө сургаал айлдаж байгаагаа мартсан юм биш биз?” хэмээн сургасан гэдэг.

Сургаал дамжуулах буюу сургаал түгээх үйл нь “аль болох олон хүнд жинхэнэ үнэнийг ухааруулж, аз жаргалтай болгох юмсан” гэсэн номын өглөг болохын зэрэгцээ өөрийнхөө сэтгэлийг сайжруулах үйл билээ.

Эрдмийн далайг эзэмдэхийг хүсмүй

Бид өөрийнхөө сайн мэдэхгүй зүйлийг хүнд дамжуулж чадахгүй. Түүнчлэн хүнд ямарваа нэг зүйлийг дамжуулахад тодорхой хэмжээний мэдлэг хэрэгтэй. Гэвч хүмүүс бидний мэдлэг, туршлага өчүүхэн юм. Ингээд бодоод үзэхээр бусдад ямар нэг зүйлийг дамжуулахад “миний мэдлэг өчүүхэн” гэсэн даруу төлөв зан чухал.





Судрын “Мөргөлийн гурван эрдэнэ” хэсэгт “Бурханы ном дор залбиран мөргөмүй - үнэхээр бүгд амьтны хамт судрын сангийн гүнд нэвтрэн орж эрдмийн далайг эзэмдэхийг хүсмүй” гэсэн байдаг. Энэ нь бидний мэдлэг өчүүхэн тул үргэлж “эрдмийн далайг эзэмдэхийг хүсмүй” хэмээн залбирч, тангараглаж байгаа утгатай. Мөн “үнэхээр бүгд амьтны хамт судрын сангийн гүнд нэвтрэн орж” гэдэг нь үргэлж тухайн нөхцөл байдалд тохирсон бурханы билиг оюуныг хүртэхийн тулд учирсан хүнээ чухалчилж, хэзээд, ямар ч хүнээс “суралцая” гэсэн сэтгэлийг мартаж болохгүй гэсэн утгатай.

“Зааж өгье гэх тусам билиг оюуны булаг ширгэж, сурья гэх тусам билиг оюуны булаг оргилон гарч ирдэг” гэж сонсож байсан. Юуг дамжуулах гэж байгаа нь хамаагүй зааж өгье, дамжуулъя гэсэн сэтгэлээс илүү хүний яриаг чих тавин сонсож, суралцъя гэсэн сэтгэлтэй байх чухал. Ингэснээр ойлгомжтой үг хэллэг, арга ухаан - өөрийгөө болон бусдыг илүү хөгжүүлэх билиг оюун ундран гарч ирэх болов уу гэж бодож байна.

Эртээд нэгэн ахлах ангийн сурагчийн илтгэлийг сонсох боломж тохиосон юм. Тэр сурагч сэтгэл хөдөлсөн зүйлээ байгаагаар нь дамжуулж байхыг сонсоод “дамжуулахад” юу чухал болохыг сурсан. Нэг үгээр хэлбэл, талархмаар, баяртай, хөгжилтэй гэж мэдэрсэн зүйлээ байгаагаар нь дамжуулах шиг хүний сэтгэлийг татах зүйл үгүй.

Үүнийг өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэгжүүлэх вэ гэвэл “талархмаар зүйл олныг олж анзаарч, бусдад дамжуулах” юм. Ингэснээр талархах сэтгэлийг хэзээ ч мартахгүй ба өдөр бүр аз жаргал, баяр хөөрийг мэдрэх болно. Үргэлж ийнхүү өөдрөг байх юм бол эргэн тойрны хүмүүс яахын аргагүй татагдаж “би ч гэсэн ийм хүн болох юмсан” гэж бодно. Энэ нь өөрөө сургаал дамжуулах үйл юм.

Бодоод үзэхээр зөвхөн хүн л талархаж чаддаг. Тийм болохоор л талархал гэдгийг үргэлж санаж, хүмүүст талархмаар зүйл олныг дамжуулцгаая.

“Косей” сэтгүүл 9-р сарын дугаараас



Амьдралын замтайгаа учирсан минь

Оклахома салбар
Жанел Жордан

*Энэхүү илтгэл 2017 оны 3 сарын 4-нд Их ариун ордонд зохион байгуулагдсан
Үүсгэн байгуулагчийн амин өдрийн ёслол дээр тавигдсан болно.*

Миний бие 2002 онд Оклахома нийгэмлэгт гишүүнээр элссэн. Тухайн үед Оклахома нийгэмлэгт найз маань бясалгалын үеэр тоглодог лимбэ хөгжмийг хэрхэн үлээхийг зааж байсан юм. Би тэр хөгжмийг сурах зорилгоор анх Оклахома нийгэмлэг дээр очсон. Тэр өдөр хичээлийн дараа Крис Ладисо тэргүүн надад нийгэмлэгээ танилцуулснаас гадна Үүсгэн байгуулагчийн бичсэн “нүдэнд харагддаггүй сормуус” номыг бэлэглэсэн. Гэр лүүгээ хариад номоо тэр дор нь уншиж дуусгав. Би тэр номноос амьдралынхаа турш хайж байсан үзэл баримтлалаа олсон юм. Энэ нь РКК-н сургаалтай учрахын эхлэл байсан.

13 наснаасаа хойш би шашны ямар нэг арга хэмжээнд оролцоогүй бөгөөд 48 нас хүртлээ шашны талаар өөрийгөө мэддэг хэмээн боддог байв. Хүүхэд байхдаа гэр бүлийнхнийхээ эрүүл мэнд, аз жаргалын төлөө гараа хавсран залбирах хэрэгтэй хэмээх заалгасан. Тиймээс гэр бүлийн гишүүдийнхээ нэрийг дуудан залбирдаг байв. Гэвч хэн нэгнийх нь нэрийг дуудахаа мартчихвал

тэр хүн нас барчихаж магадгүй гэж их айдаг байв. Яваандаа залбирал үйлдэх нь миний хувьд айдас төрүүлдэг үйл болж хувирсан юм. Тиймээс анх удаа Оклахома нийгэмлэг дээр очихдоо би бурханд залбирч чадаагүй. Айдасгүйгээр гараа хавсран залбирч чаддаг болсон маань 2006 онд төвийн арга хэмжээнд оролцохоор Токио луу явснаас хойш юм.

Анх удаа нийгэмлэгт очих үед гэртээ ирсэн юм шиг сэтгэгдэл төрж билээ. Тэр сэтгэгдэл одоо ч өөрчлөгдөөгүй. Амьдралдаа анх удаа өөрийнхөө явах ёстой зам мөрөө олсон минь тэр байв.

Насанд хүрсэн хойноо ч би гэр дотор гарах асуудлыг хэрхэн шийдэхийг мэддэггүй байсан. Харин одоо бол сургаал номноос суралцсан билиг оюун минь намайг түшиж байна.

Би аавтайгаа сайн харилцаатай биш байсан юм. Аав маань арьс өнгөөр ялгаварлах үзэлтэй хүн байсан бөгөөд түүнийгээ эргэн тойрныхноосоо нуудаггүй байлаа. Энэ үзэл нь бидний зөрчлийн гол шалтгаан байв. Мөн ээж рүү байнга орилж хашхичдаг байсан. Гэвч би сургаалын ачаар аавыгаа өвдөхөд нь хажууд нь байж чадсан юм. Аавыгаа амьсгал хураах үед би гарыг нь атгаж, дарани тарнийг уншсан.

Аавыг нас барсны дараа ээжийн зөнөглөх өвчин бүр хүндрэв. Ээжийг асрах нь миний гол үүрэг байв. Бурханы сургаалыг хэрэгжүүлснээр би эцэг эхийнхээ үхэлтэй нүүр тулж чадсан юм. Залуу байхдаа би бэрхшээлтэй асуудал тулгарангуут архи ууж, асуудлаа мартахыг хичээдэг байв. Харин одоо бол бурханы сургаал намайг түшиж байгаа болохоор архи хэрэглэх шаардлагагүй болсон.

РКК-ын сургаалын ачаар урьд өмнө мэдэргч байгаагүй жаргалтай амьдралаар амьдарч, олон сайхан учрал, сургаалаас суралцаж байна. Одоо миний амьдрал хэмжээлшгүй их талархлаар дүүрэн байна.



Илтгэл тавьж буй Жанел


Spiritual Journey

Эцэг эхийгээ асарч байх үед мөн амьдралын олон мөчлөгүүдэд намайг түшиж, дэмжиж байсан номын андууддаа чин сэтгэлээсээ талархаж байна.

Би РКК-д элссэн цагаасаа хойш сургалт, семинарт идэвхтэй оролцож байя гэж шийдсэн. 2017, 2018 онд Япон руу явж, РКК-н төв дээр зохион байгуулагдах лидерийн сургалтад хамрагдахыг тэсэн ядан хүлээж байна. Япон орон надад хоёр дахь гэр шиг минь санагддаг юм.



Лимбэ хөгжим тоглож байгаа Жанел



Их сургуульд сурдаг хүүгийнхээ талаар

Q

Хүү маань ахлах ангид байхдаа давтлагатай байсан ч гэсэн орой 11 цаг гэхэд харьж ирдэг байсан. Их сургуульд орсноос хойш цагийн ажил хийн, гэртээ шөнийн 2, 3 цагт ирэх үе ч байдаг болсон. Тийм болохоор оройн хоол хамт идэж ярилцах боломж гарахгүй, сургууль, найз нөхдийн харилцаа зэрэг нь гайгүй байгаа гэж санаа зовоод байх юм.



A

Эцэг эх гэдэг хүүхэд нь хэдэн настай болсон ч, юу ч хийж байсан санаа зовдог. Хүү тань ээжийнхээ хайранд умбаж өссөн болохоор олон зүйлд хүч сорих хүч чадвар байгаа гэж бодож байна. Та хичээж байгаа хүүгээ байгаагаар нь дэмжээд үзвэл ямар вэ? Санаа зовж байгааг тань ойлгож байгаа ч, хүүгийнхээ хиймээр байгаа зүйлийг хүндэлж, хөндлөнгөөс харж хамгаалах нь зүйтэй болов уу. Ингэснээр хүү тань амьдрах эрч хүчтэй болно.

Мөн хүүхэд их сургуульд ороод ирэхээр эцэг эхтэйгээ үзэл бодол нийлэхгүй болж ирдэг. Өөрийнх нь үзэл бодлыг ойлгож, хүлээн зөвшөөрснөөр харилцан ойлголцож чадна. Хүүхэд холдоод ирэхээр эх хүний хувьд хааяа гунигтай санагдах үе байж магадгүй ч, энэ нь хүүхэд өөрөө бодож сэтгэж, биеэ даан амьдарч сурж байгаагийн илрэл юм. Хүн хүндлүүлснээр аливаа зүйлд хариуцлагатай ханддаг болдог.

Гэхдээ л шөнийн 2, 3 цагт харьдаг гэхээр эрүүл мэндэд нь санаа зовж байгаа байх. Хүүтэйгээ уулзахаараа “эрүүл мэндэд чинь санаа зовоод байх юм” гэж бодож байгаа зүйлээ хэлэх нь чухал. Эцэг эхээсээ хол газар оюутны амьдралаар амьдардаг хүүхдүүд зөндөө байдаг. Тийм болохоор итгэж, найдаж, харж хамгаалж,

хүлээцтэй байх хэрэгтэй. Хүн өөрт нь итгэж найдах юм бол хүний итгэлийг алддаггүй.



Токио гэр бүлийн сургалт,
судалгааны институт

“Childcare Lifeline” is produced every month with the cooperation of the Tokyo Research Institute for Family Education. The institute believes that changes for the better in parents’ thinking and behavior will also bring about changes in their children. The institute holds lectures and seminars for parents throughout Japan and in other countries and also offers parents personal counseling on childrearing. Since its foundation in 1975, the institute’s programs have helped parents and children grow spiritually together to create harmonious, happy homes.



Хүүхдийнхээ төлөө залбирах

Хүү тань цагийн ажил хийж эхэлснээр мөнгө олох туршлага хуримтлуулж, нийгэмд гарч амьдрах бэлтгэлээ хийж эхэлсэн юм байна. Биеэ даах чадвартай мундаг хүү байна.

Оюутан цаг бол ирээдүйд хэрхэн амьдрахаа тодорхойлох үе. Ийм үед нь эцэг эхийн хувьд юу хийж чадах вэ? Биеэ даан хичээж байгаа хүүгийнхээ төлөө залбирч, итгэж, өөрт нь даатгах хэрэгтэй болов уу.

Эцэг эхчүүд хүүхдийнхээ төлөө юуг хүсэж залбирах чухал болох талаар Үүсгэн байгуулагч ийнхүү айлдсан байдаг. “Хүүхэд маань зан чанар, ажлаараа дамжуулж хүмүүс болон нийгэмд тустай хүн болох болтугай хэмээн залбирах хэрэгтэй. Энэ нь ертөнцийн хуульд нийцсэн хүсэл юм.”

Хүн өөрийнхөө амьдралыг өөрөө л шийдэж, өөрөө л даван туулна. Харин та “хүмүүс, нийгэмд тустай хүн болох болтугай” хэмээн залбирч, хүүдээ итгэж, дэмжиж өгөөрэй.

РKK, Сургалтын алба



Please give us your comments!



We welcome comments on our e-newsletter Living the Lotus.

E-mail: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Талархлын тэмдэглэл

Надад өглөө бүр тогтмол хийдэг нэг зугаатай ажил байдаг. Тэр бол судар уншлагын өмнө тэмдэглэлийн дэвтрээ нээж, өчигдрийн учрал, тохиолдсон зүйлсээ тэмдэглэх явдал юм.

Би тэмдэглэл хөтөлж эхлээд 20 гаруй жилийн нүүрийг үзэж байгаа ба сүүлийн 10 жил талархлын тэмдэглэл хөтлөх болсон.


Өмнөх өдрийн тохиолдсон явдал, талархмаар зүйлсээс 3-ыг тэмдэглэдэг уламжлалтай. Хүн гэдэг дургүй хүргэмээр зүйлс, бүтэлгүй явдлаа шууд л санадаг бол талархмаар зүйлийг эргэн санаж, энгийн явдлаас үнэ цэнийг нь олж харахад хичээл зүтгэл хэрэгтэй байдаг. Өглөө эрт босоод нойрмог байсан ч гэсэн тэмдэглэлээ бичиж байх зуур сэтгэл санаа амгалан тайван болж, баяр хөөр, эрч хүчээр дүүрээд ирдэг.

Тэгээд судраа уншихаар илүү чин сэтгэлээсээ уншиж чаддаг. Гайхалтай шинэ өдөр маань ийнхүү талархлын тэмдэглэлээр эхэлдэг. Тиймээс шинэ өглөөг угтахдаа би баяртай байдаг.

Талархлын тэмдэглэл хөтлөх нь өдөр тутмын амьдралд тохиолдсон талархууштай зүйлсийг олж анзаарах мэдрэмжийг хөгжүүлдэг.

Бурханы сургаалтай учирч, одоо энд байгаа аз жаргалыг олж харж чадаж байгаа өөрийгөө би үнэхээр азтай хүн гэж боддог.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Мизүтани Шёокоо



🌸 RISSHO KOSEI-KAI INTERNATIONAL BRANCHES 🌸

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2017

Rissho Kosei-kai International

3F Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street Suite #1 Los Angeles
CA 90033 U.S.A
Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437
e-mail: info@rkina.org http://www.rkina.org

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center
28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattlewashington@gmail.com
http://buddhistlearningcenter.org/

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio
6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
P.O. Box 692148, San Antonio, TX 78269, USA
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com
http://www.rkina.org/sanantonio.html

Rissho Kosei-kai of Tampa Bay
2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
Tel: (727) 560-2927
e-mail: rktampabay@yahoo.com
http://www.buddhismtampabay.org/

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org http://www.rkhawaii.org

Rissho Kosei-kai Maui Dharma Center
1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center
73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, U.S.A.
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rkina.org/losangeles.html

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
e-mail: info@rksf.org http://www.rksf.org

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: rkny39@gmail.com http://rk-ny.org/

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
Tel : 1-773-842-5654
e-mail: murakami4838@aol.com
http://home.earthlink.net/~rkchi/

Rissho Kosei-kai of Fort Myers

http://www.rkftmyersbuddhism.org/

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: rkokdc@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204, U.S.A.
Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.
http://www.rkina-dayton.com/

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377
Fax: 55-11-5549-4304
e-mail: risho@terra.com.br http://www.rkk.org.br

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil
Tel: 55-11-5549-4446/55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongzheng District, Taipei City 100, Taiwan
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433
http://kosei-kai.blogspot.com/

Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401, Taiwan
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
Tel: 976-70006960
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax : 39-06-48913949
e-mail: roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Venezia

Castello-2229 30122-Venezia Ve Italy

Rissho Kosei-kai of Paris

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France

International Buddhist Congregation (IBC)

3F Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

3F Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 *Fax:* 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division

Rissho Kosei-kai of Central Delhi

224 Site No.1, Shankar Road, New Rajinder Nagar, New Delhi,
110060, India

Rissho Kosei-kai of West Delhi

66D, Sector-6, DDA-Flats, Dwarka
New Delhi 110075, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B, P. Township, P. O. Panchasayar,
Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Singapore

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218 *e-mail:* info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station: Mirshari,
District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu

Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
Tel: 94-11-2982406 *Fax:* 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Other Groups

Rissho Kosei-kai Friends in Shanghai